

2022.02.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр:

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 19 албан бичиг ирсний 10 нь хариутай, 8 –нь хугацаандаа, 2–нь хугацаа болоогүй байна.

2022 оны 02 дугаар сарын 16 өдрийн А/19 тоот захирамжаар хэлний бодлогын салбар зөвлөл байгуулан монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

2022 оны 02 дугаар сарын 22 –ны өдрийн А/23 тоот захирамжаар Цолгүй залуу бөхчүүдийн барилдааныг 02 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулна.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: - 2022 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ. Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг , Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу бүрэн олгогдсон.

Аймгаас авах санхүүгийн дэмжлэг , төсвийн орлого 583,9 сая төгрөгийн орлого төвлөрсөн. Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн.

Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан. Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

ААНБайгууллага болон төсөвт газрууд тайлангаа санхүүгийн free balance программд шивж оруулаад байна. Төсөвт газруудын нягтлан бодогчид 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангуудаа хийж аймгийн аудитын газар, өмч, төрийн санд дуудсан хугацаанд тушаахад бэлэн болсон. Хүний нөөц болон цалингийн нэгдсэн системд баяжилт хийж ажиллаа.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар мэдээллийг цахимаар иргэдэд тогтмол хүргэж байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Ерөнхий боловсролын сургууль: . 2022 оны 02 дугаар сарын 14-нөөс хичээл сургалт 100% танхимаар эхэлсэнтэй холбогдуулан анги танхимын ариутгал, халдваргүйжүүлэлт, сургууль орчмын цэвэрлэгээ үйлчилгээ, дотуур байр, үдийн цайн хоол үйлчилгээнд сургуулийн дотоод хяналтын баг тогтмол хяналт тавьж 5 дах өдөр бүр Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газарт мэдээллийг тогтмол хүргэж байна.

Улаан загалмайн нийгэмлэг, НЭМҮТөв, БШУЯамны хамтарсан “Цар тахлын үед хүүхдийн цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулахад эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо дэмжлэг” сэдэвт цахим сургалтад Насан туршийн боловсролын багш Э.Дэчинсүрэн, эцэг эхийн төлөөлөл Ганбат, Солонго нар сургагч багшаар бэлтгэгдэн суралцлаа.

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд нэгдүгээр шатаа амжилттай төгссөн ЕБС-ын сурагчид зөвлөлийн гишүүдтэй хуралдаж, сурагчдын бичсэн төслийг уншиж танилцуулан шалгаруулж, чиглүүлэгч багш Болор-Эрдэнэ төслийг дараагийн шатанд илгээв.

Боловсролын газрын удирдах ажилтны зөвлөгөөнд ЕБС-ын захирал хамрагдлаа. Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс Боловсролын ерөнхий газартай хамтран вирус гепатит халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ

авахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Халдварт өвчний үед хариу арга хэмжээ авах” сэдэвт цахим сургалтад Нийгмийн ажилтан О.Алтангэрэл, Эмч Р.Тунгалаг нар хамрагдсан.

Соёл: Жил бүр сар шинийн баярыг угтан зохион байгуулдаг сумын “Есөн алдартан” шалгаруулах оны шилдэгүүдийн шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулж “Энх мэндийн аялгуу” хүндэтгэлийн тоглолтыг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгууллаа.

Байгууллагын дотоод ажлыг цэгцлэн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө хийж ажлын календарчилсан төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Номын сан нь ариутгал халдваргүйтгэлийн дэглэмийг баримтлан уншигчдад гэрээр ном олгон ажиллаж байна.

Гэгээн хайрын өдрийг тохиолдуулан “Хайрын баяр-2022” асуулт хариултын уралдааныг цахимаар зохион байгуулж Гэгээн Валентины өдрийг тэмдэглэх болсон түүхийг таниулан ажиллаа.

АИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 75 тоот тогтоолоор батлагдсан “Судар эгшиглэн” дэд хөтөлбөрийн хүрээнд зарлагдсан Оны шилдэг уншигч шалгаруулах Судар эгшиглэн-2022 уралдааны болзлыг танилцуулан сумын уншигчдыг дэмжих сурталчилан танилцуулах хандлагыг өөрчлөх ном унших дадал хэвшилтэй болгох зорилгоор суманд 1,2-р шатыг зохион байгуулах удирдамж төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Биеийн тамир спортын улсын хорооноос зохион байгуулж байгаа “Илүүдэл жингүй – Эртэч монгол” аяны хүрээнд байгууллага дээрээ өдөр бүр өглөөний дасгалыг хийж хэвшүүлж байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан баярын тоглолтын бэлтгэл ажилдаа ороод байна. Морин хуурын дугуйланд шинээр 3 сурагчийг хамруулан хичээллэж байна.

Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор Үдшийн цэнгүүн 2 удаа зохион байгууллаа. Мөн хурал зөвлөгөөн сургалт гэх мэт бусад үйл ажиллагаа 5 удаа зохион байгуулагдлаа.

Цэцэрлэг: Удирдах ажилтаны сургалт зөвлөгөөнд эрхлэгч хамрагдаж аймгийн хэмжээнд 4-р байранд шалгарч өмнөх амжилтаа бататгалаа.

БМДИ-ээс зохион байгуулсан сонголтод сургалтанд аргазүйч 9 бүлгийн багш хамрагдаж батламжаа гардан авлаа.

2 дугаар сарын 14-ээс зайнаас суралцаж байсан 2018 оны хүүхдүүдийг танхимд шилжүүлж 60 хүүхдийг танхимын сургалтанд хамруулж байна.

Эрүүл мэндийн төв: Тухайн сард нийт үзлэгт-362, идэвхтэй хяналт – 75 урьдчилан сэргийлэх үзлэг – 143, Больницод хэвтэн эмчлүүлсэн нийт - 47 хүүхэд 22, коронавируст халдвартай 19 байна. Алсын дуудлага 17 ирсэн дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн.

Амбулатороор үйлчлүүлж буй иргэдэд коронавирусын талаар зөвлөмж өгч гарыг ариутгаж халуун үзэж байна.

Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх файзер вакцинд 12 настай-73 хүүхдийг 1-р тунд хамруулав. 18 настай-38 хүүхдийг 3-р тунд хамруулсан.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17 ны өдрийн А/22 тоот захирамжийн дагуу “Нохой устгах” үйл ажиллагааг зохион байгуулж, эзэнгүй 92 нохойг устгасан.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийг чадавхжуулах сургалтад байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар хамрагдлаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг сумын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө /2022-2030/-г аймгийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гаргалаа.

Мал эмнэлэгийн чиглэлээр: Аймгийн мал эмнэлэгийн газраас 5 л шүлхий вакцин татан авч өвчлөл гарсан Дэлгэр багийн голомт, сэжигтэй бүс, хамгаалалтын бүсийн өрх айлын үхэр тарихаар ажлын 3 хэсэг гарган 73 өрхийн 2230 үхрийг дархлаажуулалтад хамруулаад байна.

Малын гоц халварт Шүлхий өвчин батлагдсан газар 28 хоногийн хугацаанд эмнэл зүй шинж тэмдэг, эмгэг бүтцийн хувиралт малд илрээгүй тул дэглэмээ бууруулан сумын Засаг даргын 2022 оны 02 сарын 10-ны өдрийн А/14 “Хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай” захирамж гарган постууд үргэлжлүүлэн ажиллаж, голомтын эмч өдөр тутмын үзлэг тандалт халдваргүйтгэл хийн ажиллаж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 01 сарын 27-ны өдрийн хуралдаанаар сумын 2022 оны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх эмчлэх арга хэмжээний төлөвлөгөө, Угаалга-296100, Туулгалт-147550, Боловсруулалт-190500 толгой малын тоог батлуулж Аймгийн мал эмнэлэгт хүргүүлээ.

Сумын Засаг даргын 2022 оны 02 сарын 10-ны өдрийн А/14 “Хязгаарлалтын дэглэм шилжүүлэх тухай” захирамж гарснаас хойш 14 хоногийн хугацаанд Малын гоц халдварт шүлхий өвчний эмнэл зүй шинж тэмдэг илрээгүй тул уг захирамжийг хүчингүй болгон Сумын засаг даргын 2022 оны 02 сарын 23-ны өдрийн А/24 “Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай” захирамж гарган төгсгөлийн халдваргүйтгэл хийн ажлын хэсгийг буулган хяналт тавин ажиллаж байна.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн